

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/078/НА-СТА-ТШЗ

ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛИЙН ХАРЬЯА ТӨВ АЙМАГ ДАХЬ
ПОЛИТЕХНИКИЙН КОЛЛЕЖИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasuren@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК, захирал: Ч.Мөнхтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.02.25 № 01/187
танай _____ -ны № _____ -т

ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ
СУРГУУЛИЙН ХАРЬЯА ТӨВ
АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИКИЙН
КОЛЛЕЖИЙН ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙН ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.БАТСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 254 дүгээр тогтоолоор ерөнхий боловсрол эзэмшиж байгаа мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 2.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 6.3 мянган төгрөг болгон шинэчлэн тогтоосон байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Заамар сумын хөрөнгө оруулалтаар 133,999.8 мянган төгрөгийн гурван төрлийн симулятор шилжүүлэн өгсөн нь сурагчдад зориулан сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглан боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээний ахиц гарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт бүхий нийт 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 86,2

4176020199

**Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

хувиар үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	507,820,044.60	670,219,061.77
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	206,915,688.30	368,721,226.47
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	206,915,688.30	368,721,226.47
3121	Төгрөг	206,915,688.30	368,721,226.47
31211	Төрийн сангийн харилцах	206,915,688.30	368,721,226.47
35	БАРАА МАТЕРИАЛ	300,904,356.30	301,497,835.30
351	Түүхий эд материал	4,151,791.80	4,799,891.80
35130	Эм боох материал	4,151,791.80	4,799,891.80
354	Хангамжийн материал	257,152,564.50	251,082,943.50
35410	Бичиг хэргийн материал	12,072,167.00	8,167,273.00
35420	Аж ахуйн материал	89,774,567.00	67,811,498.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,529,189.50	8,442,776.50
35450	Барилгын засварын материал	82,617,105.00	68,545,290.00
35460	Хүнсний материал	27,709,796.00	47,651,696.00
35470	Бусад хангамжийн материал	41,449,740.00	50,464,410.00
35600	Мал амьтад	39,600,000.00	45,615,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,033,108,951.71	2,319,507,479.38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,033,108,951.71	2,319,507,479.38
392	Биет хөрөнгө	1,401,111,175.71	1,690,401,578.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,474,594,550.00	1,474,594,545.15
39202	Хуримтлагдсан элэгдэл	(383,262,011.67)	(353,496,707.58)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	133,168,083.30	133,168,083.30
39204	Хуримтлагдсан элэгдэл	(133,168,083.30)	(15,458,734.30)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	261,655,140.35	352,259,300.35
39206	Хуримтлагдсан элэгдэл	(94,900,387.29)	(89,017,662.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	244,588,256.43	223,193,918.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	(130,401,126.11)	(64,421,918.18)
39217	Ном	28,836,754.00	29,580,754.00
393	Биет бус хөрөнгө	631,997,776.00	629,105,901.04
39301	Програм хангамж	11,567,500.00	11,567,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,855,833.28)	(6,747,708.24)
39303	Бусад биет бус хөрөнгө	624,286,109.28	624,286,109.28
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,540,928,996.31	2,989,726,541.15
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	29,964,203.68	18,834,178.62
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	29,964,203.68	18,834,178.62
413	Өглөг	29,964,203.68	18,834,178.62
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	595,527.68	872,278.62
4136	Бусад өглөг	29,368,676.00	17,961,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг	29,368,676.00	15,506,600.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	2,455,300.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,510,964,792.63	2,970,892,362.53

**Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

51	Засгийн газрын хувь оролцоо	2,510,964,792.63	2,970,892,362.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,198,901,961.28	1,198,901,961.28
51101	Өмч: - төрийн	1,198,901,961.28	1,198,901,961.28
512	Хуримтлагдсан үр дүн	(192,612,095.45)	337,322,862.26
51210	Өмнөх үеийн үр дүн	(192,612,095.45)	(122,604,707.64)
51220	Тайлант үеийн үр дүн	-	459,927,569.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,504,674,926.80	1,434,667,538.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,540,928,996.31	2,989,726,541.15

**Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,754,798,651.00	3,438,706,894.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	68,881,751.00	419,910,764.15
120	Нийтлэг татварын бус орлого	68,881,751.00	419,910,764.15
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,450,000.00	19,927,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,280,000.00	19,927,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,170,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	45,006,751.00	393,848,164.15
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	1,425,000.00	6,135,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,685,916,900.00	3,018,796,130.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,352,031,300.00	2,675,833,730.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,352,031,300.00	2,675,833,730.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	333,885,600.00	342,962,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	333,885,600.00	342,962,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,523,113,864.31	2,978,779,324.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,523,113,864.31	2,978,779,324.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,409,246,821.92	2,926,943,324.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,439,318,628.71	1,826,300,062.16
210101	Үндсэн цалин	598,524,052.36	949,933,037.52
210102	Нэмэгдэл	703,571,168.05	728,549,994.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,227,000.00	52,957,000.00
210104	Урамшуулал	105,996,408.30	94,860,030.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	181,809,999.09	228,957,903.61
210201	Тэтгэврийн даатгал	126,068,615.50	156,467,101.78
210202	Тэтгэмжийн даатгал	12,335,256.79	18,310,368.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,456,231.23	9,844,134.03
210204	Ажилгүйдлийн даатгал	7,188,955.75	8,819,163.27
210205	Эрүүл мэндийн даатгал	28,760,939.82	35,517,136.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	309,392,595.28	294,941,754.67
210301	Гэрэл, цахилгаан	33,301,995.28	21,156,154.67
210302	Түлш, халаалт	273,790,600.00	273,785,600.00
210303	Цэвэр, бохир ус	2,300,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	-	85,335,616.00
210401	Бичиг хэрэг	-	14,015,674.00
210402	Тээвэр, шатахуун	-	15,402,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	3,028,850.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	2,014,199.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	22,664,703.00
210408	Бараа материал актгалсны зардал	-	28,210,190.00
2105	Нормативт зардал	108,021,364.00	148,070,500.00

**Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	1,249,400.00
210502	Хоол, хүнс	108,021,364.00	146,821,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,533,400.00	39,927,969.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,429,000.00	499,000.00
210604	Урсгал засвар	1,104,400.00	39,428,969.00
2107	Томилолт, зочны зардал	-	4,820,000.00
210702	Дотоод албан томилолт	-	4,820,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	10,276,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	10,276,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	366,170,834.84	288,313,519.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	93,668,203.91	19,186,160.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	97,661,100.00	136,157,571.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	174,841,530.93	132,969,788.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,867,042.39	51,835,999.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	91,868,437.67	42,930,030.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	62,495,137.67	14,930,030.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	26,966,000.00	28,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,407,300.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	21,998,604.72	8,905,969.33
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,998,604.72	8,905,969.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	231,684,786.69	459,927,569.90
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,000,000.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	15,000,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(15,000,000.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	216,684,786.69	459,927,569.90

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,703,196,900.00	3,038,843,730.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,280,000.00	20,047,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	17,280,000.00	20,047,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,280,000.00	20,047,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,280,000.00	20,047,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,685,916,900.00	3,018,796,130.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,352,031,300.00	2,675,833,730.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,352,031,300.00	2,675,833,730.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	333,885,600.00	342,962,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	333,885,600.00	342,962,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,405,655,481.70	2,851,518,039.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,405,655,481.70	2,851,518,039.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,291,788,439.31	2,799,682,040.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,438,955,037.32	1,825,577,993.54
210101	Үндсэн цалин	821,604,424.98	957,724,476.17
210102	Нэмэгдэл	483,386,541.65	720,063,671.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,157,560.16	53,049,591.71
210104	Урамшуулал	105,806,510.53	94,740,254.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	181,578,062.80	229,403,221.29
210201	Тэтгэврийн даатгал	123,633,803.63	156,742,804.19
210202	Тэтгэмжийн даатгал	14,538,132.37	18,232,391.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,456,231.23	9,600,444.84
210204	Ажилгүйдлийн даатгал	7,188,955.75	8,950,478.71
210205	Эрүүл мэндийн даатгал	28,760,939.82	35,877,102.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	309,392,595.28	324,310,430.67
210301	Гэрэл, цахилгаан	33,301,995.28	21,156,154.67
210302	Түлш, халаалт	273,790,600.00	303,154,276.00
210303	Цэвэр, бохир ус	2,300,000.00	-
2105	Нормативт зардал	112,893,670.00	170,117,290.00
210502	Хоол, хүнс	112,893,670.00	170,117,290.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,202,400.00	22,291,199.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	18,708,000.00	12,545,199.00
210604	Урсгал засвар	2,494,400.00	9,746,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	227,766,673.91	227,981,906.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	111,305,823.91	81,459,352.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	116,460,850.00	146,522,554.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,867,042.39	51,835,999.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	91,868,437.67	42,930,030.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	62,495,137.67	14,930,030.00

**Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	26,966,000.00	28,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,407,300.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	21,998,604.72	8,905,969.33
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,998,604.72	8,905,969.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	297,541,418.30	187,325,690.17
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	90,625,730.00	25,520,152.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	90,625,730.00	25,520,152.00
2200	Дотоод эх үүсвэрээр	90,625,730.00	25,520,152.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	90,625,730.00	25,520,152.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(90,625,730.00)	(25,520,152.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	206,915,688.30	161,805,538.17
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	206,915,688.30
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	206,915,688.30	368,721,226.47

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	574,615,852.00	435,473,427.14	(272,562,563.97)	737,526,715.17
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	574,615,852.00	435,473,427.14	(272,562,563.97)	737,526,715.17
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	624,286,109.28	-	(27,912,543.01)	596,373,566.27
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,198,901,961.28	1,504,674,926.80	(192,612,095.45)	2,510,964,792.63
2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,198,901,961.28	1,504,674,926.80	(192,612,095.45)	2,510,964,792.63
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	70,007,387.81	70,007,387.81
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,198,901,961.28	1,504,674,926.80	(122,604,707.64)	2,580,972,180.44
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(70,007,387.81)	-	(70,007,387.81)
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	459,927,569.90	459,927,569.90
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,198,901,961.28	1,434,667,538.99	337,322,862.26	2,970,892,362.53

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,076,939,700.00	3,029,937,760.67	47,001,939.33	98.47
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,689,728,400.00	2,675,833,730.00	13,894,670.00	99.48
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,689,728,400.00	2,675,833,730.00	13,894,670.00	99.48
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	342,962,400.00	334,056,430.67	8,905,969.33	97.40
132001	Орон нутгийн төсвөөс	342,962,400.00	334,056,430.67	8,905,969.33	97.40
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	44,248,900.00	20,047,600.00	24,201,300.00	45.31
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,747,600.00	20,047,600.00	(300,000.00)	101.52
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	24,501,300.00		24,501,300.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,076,939,700.00	2,868,132,222.50	208,807,477.50	93.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,076,939,700.00	2,868,132,222.50	208,807,477.50	93.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,034,009,600.00	2,825,202,192.50	208,807,407.50	93.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,907,628,200.00	1,825,577,993.54	82,050,206.46	95.70
210101	Үндсэн цалин	1,036,918,200.00	957,705,396.17	79,212,803.83	92.36
210102	Нэмэгдэл	818,942,200.00	720,082,751.14	98,859,448.86	87.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	51,767,800.00	53,049,591.71	(1,281,791.71)	102.48
210104	Урамшуулал	-	94,740,254.52	(94,740,254.52)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	238,453,400.00	229,403,221.29	9,050,178.71	96.20
210201	Тэтгэврийн даатгал	162,148,400.00	156,742,804.19	5,405,595.81	96.67
210202	Тэтгэмжийн даатгал	19,076,200.00	18,232,391.11	843,808.89	95.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,538,100.00	9,600,444.84	(62,344.84)	100.65
210204	Ажилгүйдлийн даатгал	9,538,100.00	8,950,478.71	587,621.29	93.84
210205	Эрүүл мэндийн даатгал	38,152,600.00	35,877,102.44	2,275,497.56	94.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	332,962,400.00	324,310,430.67	8,651,969.33	97.40
210301	Гэрэл, цахилгаан	22,949,600.00	21,156,154.67	1,793,445.33	92.19
210302	Түлш, халаалт	303,285,600.00	303,154,276.00	131,324.00	99.96
210303	Цэвэр, бохир ус	6,727,200.00	-	6,727,200.00	-
2105	Нормативт зардал	214,194,900.00	170,117,290.00	44,077,610.00	79.42
210502	Хоол, хүнс	214,194,900.00	170,117,290.00	44,077,610.00	79.42
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,511,300.00	25,720,799.00	(1,209,499.00)	104.93
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	14,511,300.00	15,974,799.00	(1,463,499.00)	110.09
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,746,000.00	254,000.00	97.46
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,609,500.00	-	52,609,500.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,333,500.00	-	42,333,500.00	-
210801	Аудит бат, зэрэглэл тогтоох	10,276,000.00	-	10,276,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	263,649,900.00	250,072,458.00	13,577,442.00	94.85

**Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	123,649,000.00	101,544,904.00	22,104,096.00	82.12
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	140,000,900.00	148,527,554.00	(8,526,654.00)	106.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,930,100.00	42,930,030.00	70.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,930,100.00	42,930,030.00	70.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,930,100.00	14,930,030.00	70.00	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,000,000.00	28,000,000.00	-	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		206,915,688.30		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		368,721,226.47		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 3,012,203.5 мянган төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Санхүүгийн байдлын тайлангийн тайланд үеийн үр дүнг 216,684.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

Санхүүгийн мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан 8,847.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн биет ба биет бус хөрөнгийн зардалд тайлагнаагүй.

Мөнгөн гүйлгээ болон үр дүнгийн тайланд төрийн сангийн 100141315010 дансанд орсон 2,250.0 мянган төгрөгийн орлогыг бүртгэлд тусгаагүй.

Санхүүгийн үр дүнгийн тайланд 8,525.0 мянган төгрөгийн эмийн зардал, 6,096.7 мянган төгрөгийн бичиг хэргийн зардал, 38,120.0 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал, 61,868.1 мянган төгрөгийн урсгал засварын зардал, 22,006.5 мянган төгрөгийн тээвэр шатахууны зардал, 11,782.6 мянган төгрөгийн хоолны зардал, 4,820.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг тус тус нийт 153,218.9 мянган төгрөгийг бусад зардалд тайлагнасан.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд 2,485,341.5 мянган төгрөгийг батлагдсан төсвийг тайлагнаагүй.

Тайлант онд хүлээн авсан 2,955.0 мянган төгрөгийн малын төлийг бүртгэлд тусгаагүй.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын 133,999.8 мянган төгрөгийн санхүүжилтээр политехникийн тоног төхөөрөмж нийлүүлэх ТӨАЗСЗТГ/20250102033-04 дугаартай гэрээг дүгнэн тоног төхөөрөмжийг 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдөр хүлээн авсан боловч бүртгэлд тусгаагүй.

Тайлант оны эцэст орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 8,905.9 мянган төгрөгийг орон нутгийн санхүүжилтээр бүртгэснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2-т "нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж тус тус заасны дагуу санхүүгийн тайланд залруулга хийсэн.

Аудитаар илэрсэн 12,946.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 22,042.3 мянган төгрөгөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 12,946.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 12,946.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

5.1 Албан шаардлага

1.Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 254 дүгээр тогтоолын дагуу тайлант онд суралцсан дотуур байрны давхардсан тоогоор 21.250 сурагчдад ногдох нормативаар тооцоход 133,875.0 мянган төгрөгийн зарцуулахаас 146,821.1 мянган төгрөг зарцуулж 12,946.1 мянган төгрөгийг илүү зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.4-т "Орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцоох аргачлал, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх үйлчилгээний стандарт, тэдгээрийн орцын болон төсвийн нормативыг Засгийн газар тогтооно", Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 254 дүгээр тогтоолын 1-т "ерөнхий боловсролын сургуулийн 1-5

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

дугаар ангийн хүүхдийн нэг өдрийн үдийн хоолны түүхий эдийн зардлыг 2.5 мянган төгрөгөөр тогтоосугай" гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн: Сурагчдын хоолны түүхий эдийн зардлыг тооцоог батлагдсан нормативаас илүү бодож олгох зөрчлийг зогсоох албан шаардлага өгөв.

2.Хичээл үйлдвэрлэлийн материалын зарцуулалт хийхдээ багшийн дадлагын ажил гүйцэтгэхэд шаардлагатай материалын нормын хүснэгт, сургалтын менежерийн гарын үсэгтэй материал гаргах хүсэлт, дадлагын ажлын хөтлөлт, зураг, ажлын карт, үнэлгээний хуудасгүйгээр нийт 14,453.8 мянган төгрөгийн бараа материалыг зарлагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Хичээл үйлдвэрлэлийн дадлагын материалын зарцуулалтыг сургалтын менежерийн зөвшөөрөлтэй материал гаргах хүсэлт, дадлагын ажлын гүйцэтгэлийг нотлох баримт бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулж, зөрчлийг зогсоох албан шаардлага өгөв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-д "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-д "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй, "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 14 ширхэг 36,914.8 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" тухай 271 дүгээр тогтоолын 7.1-д "төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны ертөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг Төв аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн байдлын тайланд тайлант үеийн үр дүнг 216,684.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	216,684.8	1	216,684.8			1	216,684.79		
2	Санхүүгийн мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан 8,847.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн биет ба биет бус хөрөнгийн зардалд тайлагнаагүй.	1	8,847.5	1	8,847.			1	8,847.50		
3	Мөнгөн гүйлгээ болон үр дүнгийн тайланд төрийн сангийн 100141315010 дансанд орсон 2,250.0 мянган төгрөгийн орлогыг бүртгэлд тусгаагүй.	1	2,250.0	1	2,250.0			1	2,250.00		
4	Санхүүгийн үр дүнгийн тайланд 8,525.0 мянган төгрөгийн эмийн зардал, 6,096.7 мянган төгрөгийн бичиг хэргийн зардал, 38,120.0 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал, 61,868.1 мянган төгрөгийн урсгал засварын зардал, 22,006.5 мянган төгрөгийн тээвэр шатахууны зардал, 11,782.6 мянган төгрөгийн хоолны зардал, 4,820.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг тус тус нийт 153,218.9 мянган төгрөгийг бусад зардалд тайлагнасан.	1	153,218.9			1	153,218.9	1	153,218.9		
5	Тайлант оны эцэст орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 8,905.9 мянган төгрөгийг орон нутгийн санхүүжилтээр бүртгэсэн.	1	8,905.9			1	8,905.9	1	8,905.9		
6	Төсвийн гүйцэтгэлийн тайланд 2,485,341.5 мянган төгрөгийг батлагдсан төсвийг тайлагнаагүй.	1	2,485,341.5	1	2,485,341.5			1	2,485,341.50		
7	Тайлант онд хүлээн авсан 2,955.0 мянган төгрөгийн малын төлийг бүртгэлд тусгаагүй.	1	2,955.0	1	2,955.0			1	2,955.00		
8	Төв аймгийн Заамар сумын Засаг даргын тамгын газрын 133,999.8 мянган төгрөгийн санхүүжилтээр политехникийн тоног төхөөрөмж нийлүүлэх ТӨАЗСЗТГ/20250102033-04 дугаартай гэрээг дүгнэн	1	133,999.8	1	133,999.8			1	133,999.80		

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	тоног төхөөрөмжийг 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдөр хүлээн авсан боловч бүртгэлд тусгаагүй.										
	Дү	8	3,012,203.5	6	2,850,078.1	2	162,124.8	8	3,012,203.5		

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 14 ширхэг 36,914.8 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй байна.	1						1					
2	Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 254 дүгээр тогтоолын дагуу тайланд онд суралцсан дотуур байрны давхардсан тоогоор 21.250 сурагчдад ногдох нормативаар тооцоход 133,875.0 мянган төгрөгийн зарцуулахаас 146,821.1 мянган төгрөг зарцуулж 12,946.1 мянган төгрөгийг илүү зарцуулсан.	1	12,946.1			1	12,946.1						
3	Хичээл үйлдвэрлэлийн материалын зарцуулалт хийхдээ багшийн дадлагын ажил гүйцэтгэхэд шаардлагатай материалын нормын хүснэгт, сургалтын менежерийн гарын үсэгтэй материал гаргах хүсэлт, дадлагын ажлын хөтлөлт, зураг, ажлын карт, үнэлгээний хуудасгүйгээр нийт 14,453.8 мянган төгрөгийн бараа материалыг зарлагдсан байна.	1				1							
4	Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.	1						1					
	Дүн	4	12,946.1			2	12,946.1	2					0

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 124 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 30 мэдээлэл, байршуулаагүй 17 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 1,117,296.5 мянган төгрөгийн 21 гүйлгээ, зарлагын 331,232.3 мянган төгрөгийн 16 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 1,828,685.0 мянган төгрөгийн 42 гүйлгээ, зарлагын 134,664.3 мянган төгрөгийн 10 гүйлгээ тус тус байршуулаагүй. Мөн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт болон аудитын зөвлөмжийн мөрөөр хийх ажлын төлөвлөгөө тайлан тус тус байршуулаагүй байна. Таван саяас дээш орлого, зарлагын гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд байршуулахдаа дараа сард нь өссөн дүнгээр байршуулсан.	1	3,411,878.2			1	3,411,878.2		-
Дүн	1	-						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	3,411,878.2			1	3,411,878.2		

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 42-20810579-ТӨА-2026/078/НА-СТА-ТШЗ Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллеж нь тайлант онд нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 124 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 30 мэдээлэл, байршуулаагүй 17 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 1,117,296.5 мянган төгрөгийн 21 гүйлгээ, зарлагын 331,232.3 мянган төгрөгийн 16 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 1,828,685.0 мянган төгрөгийн 42 гүйлгээ, зарлагын 134,664.3 мянган төгрөгийн 10 гүйлгээ, санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт болон аудитын зөвлөмжийн мөрөөр хийх ажлын төлөвлөгөө тайланг тус тус байршуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх", Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.5-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.10-д "Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар" гэж заасантай тус тус нийцэхгүй байна. Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батсүрэн, нягтлан бодогч Д.Чанцалдулам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 41-20810579-ТӨА-2026/078/НА-СТА-ТШЗ

Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайланд онд дотуур байранд байрладаг сурагчдын өдрийн хоолыг олгох батлагдсан нормативаас 12,946,100 /арван хоёр сая есөн зуун дөчин зургаан мянга нэг зуу/ төгрөгөөр илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.4-т "Орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцоох аргачлал, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх үйлчилгээний стандарт, тэдгээрийн орцын болон төсвийн нормативыг Засгийн газар тогтооно", Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 254 дүгээр тогтоолын 3-т "Ерөнхий боловсрол эзэмшиж байгаа мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6300 (зургаан мянга гурван зуу) төгрөгөөр тогтоосугай" гэж заасныг мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан нормативын дагуу сурагчдын хоолны зардлыг тооцож олгох, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батсүрэн, нягтлан бодогч Д.Чанцалдулам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 43-20810579-ТӨА-2026/078/НА-СТА-ТШЗ

Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хичээл үйлдвэрлэлийн материалын зарцуулалт хийхдээ багшийн дадлагын ажил гүйцэтгэхэд шаардлагатай материалын нормын хүснэгт, сургалтын менежерийн гарын үсэгтэй материал гаргах хүсэлт, дадлагын ажлын хөтлөлт, зураг, ажлын карт, үнэлгээний хуудасгүйгээр нийт 14,453,790 /арван дөрвөн сая дөрвөн зуун тавин гурван мянга долоо зуун ерэн/ төгрөгийн бараа материалыг зарлагадсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна. Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хичээл үйлдвэрлэлийн дадлагын материалын зарцуулалтыг анхан шатны баримт бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулж, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехникийн коллежийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батсүрэн, нягтлан бодогч Д.Чанцалдулам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn